



ДОРНОД АЙМГИЙН ОНЦГОЙ КОМИССЫН
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

2021 оны 04 дугаар сарын 09 өдөр Дугаар 34

Хэрлэн сум

XXXIV ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

Аймгийн Онцгой комиссын 34 дүгээр хуралдаан 2021 оны 04 дүгээр сарын 09-ний өдрийн 18:00 цагт аймгийн Засаг даргын Тамгын газрын хурлын танхимд 92,5 хувийн ирцтэй хуралдав.

Хуралдааныг аймгийн Засаг дарга, Онцгой комиссын дарга М.Бадамсүрэн даргалж холбогдох үүрэг даалгаврыг өгөв.

СОНССОН НЬ:

1.Монгол Улсын Засгийн газрын 2021 оны "Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх тухай" 91 дүгээр тогтоолын хэрэгжилтийг хангах талаар аймгийн Онцгой комиссоос авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал танилцуулах,

АЗДТГ-ын дарга П.Бат-Өлзий

2."Петрочайна Дачин Тамсаг" ХХК-аас аймгийн Онцгой комисст ирүүлсэн "Хилийн Баянхошуу боомтоор тусгай тоноглол бүхий техник, багаж хэрэгслийг нэвтрүүлэх тухай" хүсэлтийг Улсын Онцгой комисст уламжлах албан бичгийн төсөл танилцуулах,

АЗДТГ-ын Хууль эрх зүйн хэлтэс

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Нэг.Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга,

Онцгой комиссын гишүүн П.Бат-Өлзий,

АЗДТГ-ын Хууль эрх зүйн хэлтсийн дарга, Онцгой комиссын

гишүүн Ц.Баяржаргал,

Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газрын дарга, Онцгой комиссын

орлогч дарга, хурандаа Г.Нармандах нарт:

1.1.Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 91 дүгээр тогтоолоор Улсын хэмжээнд гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэг "Улаан" түвшинд шилжсэн хугацаа буюу 2021 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн 06:00 цагаас 2021 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн 00:00 цаг хүртэл МУ-ын Засгийн газрын 2021 оны 45 дугаар тогтоолоор баталсан "Коронавируст халдвар /COVID-19/-ын тархалтын түвшинг тогтоож, төрийн байгууллага, хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагааг зохицуулах" түр журмын дагуу төрийн байгууллага, хуулийн этгээд, иргэдийн үйл ажиллагааг зохицуулах,

М.Бадамсүрэн

/М.Бадамсүрэн

Д.Баттулга

/Д.Баттулга

Эрүүл мэндийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн Ч.Оюунаа,
Мэргэжлийн хяналтын газрын дарга, Онцгой комиссын гишүүн Д.Мөнхтуяа,
Сумын Засаг дарга, Онцгой комиссын дарга нарт:

1.2.Дорнод аймгийн төв болон сумын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа эрхэлдэг албан байгууллагын өрөө тасалгаа, байр, орон сууцны орц, хонгил, цонх, цахилгаан шат, хүүхдийн тоглоомын талбай зэрэг халдвар тархах эрсдэл бүхий орчныг халдваргүйтгэх ажлыг зохион байгуулах,

Эрүүл мэндийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн Ч.Оюунаа,
Цагдаагийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн, цагдаагийн хурандаа Т.Ганзориг,
Сумын Засаг дарга, Онцгой комиссын дарга нарт:

1.3.Бүх нийтийн бэлэн байдлын үед иргэдэд эмнэлгийн тусламж, үйлчилгээ, түлш, зөөврийн ус, хүнс, ахуйн хэрэглээний бараа бүтээгдэхүүн худалдан авах, эмийн сангаар үйлчлүүлэх, шинжилгээ, дархлаажуулалтад хамрагдах зохицуулалтаар хангах,

Цагдаагийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн, цагдаагийн хурандаа Т.Ганзориг,
Сумын Засаг дарга, Онцгой комиссын дарга нарт:


1.4.Иргэдийн эрүүл мэндийг дэмжих, хөдөлгөөний дутагдлаас сэргийлэх зорилгоор оршин суугаа газрын гадна талбай, цэцэрлэгт хүрээлэн, тоглоомын талбайд алхах, дугуй унах, биеийн тамирын дасгал хөдөлгөөн хийхийг хатуу хязгаарлахгүйгээр хүн хоорондын зайг хатуу барих, нэг дор 3-аас илүү хүн цуглахгүй /гэр бүлийн хүрээнээс бусад/ байх талаар иргэдэд мэдээлэх, хяналт тавьж ажиллах,

Сумын Засаг дарга, Онцгой комиссын дарга,
Багийн Засаг дарга нарт:

1.5.Оршуулга, буяны үйл ажиллагаанд оролцсон иргэдээс халдвар тархах эрсдэл өндөр байгаа тул зөвхөн садан төрөл оролцох, тодорхой хязгаарлалттайгаар хүний тоог зааж зохион байгуулах талаар иргэдэд зөвлөмж, анхааруулга өгөх, хяналт тавьж ажиллах,

Эрүүл мэндийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн Ч.Оюунаа,
Сумын Засаг дарга, Онцгой комиссын дарга нарт:

1.6.Орон нутгийн эрүүл мэндийн салбар, хариу арга хэмжээний баг, стратегийн ач холбогдол бүхий салбарын ажилтан, албан хаагч, иргэдийг дархлаажуулах ажлыг зохион байгуулах,

 / М.Бадамсүрэн
/ Д.Баттулга

Эрүүл мэндийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн Ч.Оюунаа,
Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн захирал, Онцгой комиссын гишүүн Д.Должин,
Аймгийн ерөнхий тархвар судлаач эмч, Онцгой комиссын гишүүн Б.Ганганцэцэг,
Хэрлэн сумын Засаг дарга бөгөөд Чойбалсан хотын захирагч, Онцгой комиссын гишүүн О.Пүрэв-Очир нарт:

1.7.Коронавирусын халдвар бүртгэгдсэн Хэрлэн суманд хавьтал тогтоох, тандалт судалгаа, эрт илрүүлэг хийх ажлыг зохион байгуулах,

Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн захирал, Онцгой комиссын гишүүн Д.Должин-д,

1.8.Эрүүл мэндийн байгууллагаар үйлчлүүлэгчдээс ПГУ /PCR/ шинжилгээ авах, хариуг богино хугацаанд гаргах, шинжилгээнд хамрагдаж буй иргэдийг чирэгдэлгүй үйлчлүүлэх нөхцөлийг бүрдүүлж ажиллах,

Эрүүл мэндийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн Ч.Оюунаа,
Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн захирал, Онцгой комиссын гишүүн Д.Должин,
Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газрын дарга, Онцгой комиссын орлогч дарга, хурандаа Г.Нармандах нарт:

1.9.Аймгийн хэмжээнд шаардлагатай түргэвчилсэн оношлуурын нөөцийг нэмэгдүүлэх, хүчилтөрөгчийн аппарат, зөөврийн баллон, дагалдах хэрэгслийн нөөцийг шаардлагатай хэмжээнд бүрдүүлж, халдварыг оношлох, эмнэлгийн тусламж үйлчилгээг шуурхай зохион байгуулах,

Сумын Засаг дарга, Онцгой комиссын дарга, Сум, өрхийн Эрүүл мэндийн төвийн дарга нарт:


1.10.Зорилтот бүлгийн өрхөд нэг удаа хүнсний тусламж, 60 ба түүнээс дээш насны ахмадуудад дархлаажуулах аяныг өрнүүлэх, заавар, зөвлөмж хүргэж ажиллах,

Мэргэжлийн хяналтын газрын дарга, Онцгой комиссын гишүүн Д.Мөнхтуяа-д:

1.11.Уул уурхайн бүтээгдэхүүн, экспорт, импортын ачаа тээвэрлэгч аж ахуйн нэгж, байгууллагуудын хөрөнгө оруулалтаар Баянхошуу хилийн боомтод олон улсын стандартад нийцсэн халдваргүйжүүлэлтийн цэгийг байгуулах, байнгын ажиллагаанд оруулан хяналт тавьж ажиллах,

Аймгийн Онцгой комиссын гишүүдэд:

1.12.Аймгийн Эрүүл мэндийн шуурхай штабт иргэдээс ирүүлсэн өргөдөл, хүсэлтийг шуурхай шийдвэрлэх, нэмэлтээр агентлагуудаас төрийн албан хаагчдыг дайчлан ажиллуулах,

 / М.Бадамсүрэн
/ Д.Баттулга

Боловсрол, соёл урлагийн газрын дарга, Онцгой комиссын
гишүүн А.Нансалмаа-д:

1.13.Гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэг "Улаан" түвшинд шилжиж хөл хорио тогтоосонтой холбогдуулан ерөнхий боловсролын сургуулийн багш нарыг бүх нийтийн эргүүлд татан оролцуулах ажлыг зохион байгуулах,

АЗДТГ-ын Хууль эрх зүйн хэлтсийн дарга, Онцгой комиссын
гишүүн Ц.Баяржаргал-д:

1.14.Аймгийн Онцгой комиссын 2021 оны "Хязгаарлалтын дэглэм тогтоох тухай" 29 дүгээр тогтоол, "Тогтоолд өөрчлөлт оруулах тухай" 31 дүгээр тогтоолыг хүчингүй болгож Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 91 дүгээр тогтоолоор Улсын хэмжээнд гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэн хугацаад спиртын бага агууламж бүхий /18 хувиас доош/ согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх цагийн хязгаарыг Баасан гарагаас бусад өдөрт 10:00-20:00 цагт зөвшөөрч спиртын өндөр агууламж бүхий /18 хувиас дээш/ согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэхийг хориглох тухай тогтоол гаргах,

Цагдаагийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн,
цагдаагийн хурандаа Т.Ганзориг,
Сумын Засаг дарга, Онцгой комиссын дарга нарт:

1.15.Хүндэтгэн үзэх шалтгаан /эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, буяны ажил/, зөвшөөрөгдсөн ачаа тээвэрлэлтээс бусад тохиолдолд аймгийн төв, сумдаас орох, гарах чиглэлд иргэд, тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг хязгаарлах,

Цагдаагийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн,
цагдаагийн хурандаа Т.Ганзориг-т:

1.16.Гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэг "Улаан" түвшинд шилжиж хөл хорио тогтоосонтой холбогдуулан хөдөлгөөнт эргүүлийг зохион байгуулахад шаардагдах шатахуун, хамгаалалтын тууз, нийтийн эргүүлд ажиллах байгууллага, аж ахуйн нэгж болон үүрэг гүйцэтгэх албан хаагчдын хувийн тээврийн хэрэгсэлд ялгах тэмдэг хийлгэх зардлуудыг тооцож аймгийн Засаг даргын зөвлөлийн дараагийн хуралд танилцуулах,

1.17.Тусгай дуут болон гэрэл дохиогоор тоноглогдсон тээврийн хэрэгсэл эзэмшигч байгууллагуудын тээврийн хэрэгслийг эргүүл, шалгалтын үйл ажиллагаанд татан оролцуулахыг дэмжив,

Цагдаагийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн,
цагдаагийн хурандаа Т.Ганзориг,
Эрүүл мэндийн газрын дарга, Онцгой комиссын
гишүүн Ч.Оюунаа,
Сумын Засаг дарга, Онцгой комиссын дарга нарт:

1.18.Хэрлэн суманд батлагдсан тохиолдол бүртгэгдсэнтэй холбогдуулан 2021 оны 04 дүгээр сарын 06-ны өдрөөс 2021 оны 04 дүгээр сарын 13-ны өдрүүдэд бусад сум руу зорчсон иргэд ПГУ /PCR/-ын шинжилгээ өгөхгүй явж болно, тухайн суманд очоод 7 хоног гэрийн тусгаарлалтад байх, хяналт тавьж ажиллах тухай аймгийн Онцгой комиссын тогтоол гаргах,

 / М.Бадамсүрэн
/ Д.Баттулга

Хоёр.АЗДТГ-ын Хууль эрх зүйн хэлтсийн дарга, Онцгой комиссын гишүүн Ц.Баяржаргал-д:

2.1.“Петрочайна Дачин Тамсаг” ХХК-аас аймгийн Онцгой комисст ирүүлсэн “Хилийн Баянхошуу боомтоор тусгай тоноглол бүхий техник, багаж хэрэгслийг нэвтрүүлэх тухай” хүсэлтийг аймгийн Онцгой комиссоос албан бичгээр Улсын Онцгой комисст уламжлахыг тус тус үүрэг болгов.

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА, ОНЦГОЙ КОМИССЫН ДАРГА М.БАДАМСҮРЭН

АЙМГИЙН ОНЦГОЙ КОМИССЫН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА, ДЭД ХУРАНДАА Д.БАТТУЛГА



A handwritten signature in black ink, written over the bottom part of the red stamp.